



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 09 сарын 13 өдөр

Дугаар А/459

Хэрлэн сум

Үзэсгэлэн худалдаа зохион байгуулахад
хөрөнгө зарцуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 2020 оны аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2 дугаар хуралдааны аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай 06 дугаар тогтоол, 2021 оны аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 8 дугаар хуралдааны аймгийн 2022 оны төсөв батлах тухай 4 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан “Цагаан идээ” үзэсгэлэн худалдааг 2022 оны 9 дүгээр сарын 16-аас 2022 оны 9 дүгээр сарын 17-д зохион байгуулахад зориулж 2,500,000 (хоёр сая таван зуун) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2. Зардлын тооцоог нэгдүгээр хавсралтаар, удирдамжийг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

3. Шаардагдах зардлыг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Э.Мөнх-Эрдэнэ)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ